

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1.	Аудитын гэрчилгээ	3
2.	Аудитын тайлан	3
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргагүй, шалгуур үзүүлэлт	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8.	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.10.	Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	10
2.11.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12.	Шилэн дансны мэдээлэл	8
2.13.	Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	8
2.14.	Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3.	Менежментийн захидал	9
3.1	Зардлын данстай холбоотой асуудал.....	9
3.2	Зардлын данстай холбоотой асуудал.....	10
3.3	Зардлын данстай холбоотой асуудал.....	11
4.	Аудит хийсэн санхүүгийн тайлан	12
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19
5.	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
САГ	Санхүүгийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



ЦАГААННУУР ЧӨЛӨӨТ БҮСИЙН
ЗАХИРАГЧ А.АМАНКЕЛДИ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.02.20 № 06/538
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагааннуур чөлөөт бүсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Цагааннуур чөлөөт бүсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Цагааннуур чөлөөт бүсийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Цагааннуур чөлөөт бүсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Цагааннуур чөлөөт бүсийн захирагч А.Аманкелди Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн зардлын дансны нягтлан бодох бүртгэл, тайлагналыг холбогдох стандарт дүрэм, журмын дагуу бүртгэх, үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөлттэй холбоотой зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагааннуур чөлөөт бүсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагааннуур чөлөөт бүсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 23-аас 2020 оны 02 дугаар сарын 17-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Мишээл-Од Аудит ХХК-ийн захирал Т.Одончимэг хоёр дахь шатны, чанарын хяналтын менежер Э.Энхцэцэг анхан шатны хяналт хэрэгжүүлэхээр, ахлах аудитор О.Цэндхүү, аудиторовын туслах Т.Алтанчимэг, Ш.Тэгш-Ерөөлт нар хариуцаж хэрэгжүүлэв.

Цагааннуур чөлөөт бүс нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Цагааннуур чөлөөт бүс нь олон улсын түвшинд хүрсэн жишиг чөлөөт бүсийг байгуулж, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын өсөлтийг тэргүүлэгч, эрчимтэй хөгжлийн төв болгон, баруун бүс нутгийн хөгжлийг хурдасгах замаар Монгол Улсын нийгэм, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд оршино гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Цагааннуур чөлөөт бүсийн үндсэн үйл ажиллагаа нь гадаад худалдаа юм. Гэвч энэ чиглэлээр тодорхой ажлууд хийгдээгүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 тоот тогтоолоор “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”, “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”, “Төрийн албан хаагчид докторын зэрэг, профессор цолны нэмэгдэл олгох журам”, “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”, “Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журам”, “Төрийн үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”;
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 5 тоот тогтоолоор “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”, “Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан, хүндэт тэмдгийн төрөл, түүнийг олгох эрх бүхий албан тушаалтны жагсаалт”, “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”;
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 276 дугаар тогтоолоор баталсан “Шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл”, “Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл”, “Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл”;
- “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 24 дүгээр тогтоол;
- Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмэгдүүлсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон;
- Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ыг Монгол Улсын Сангийн сайдын 2019 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 74 дугаар тушаалаар баталсан.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Тус байгууллагын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэхгүй, шинэчлэн боловсруулах шаардлагатай байгаад зөвлөмж өгөхөөр болсон.

Цагааннуур чөлөөт бүс нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Юникус” програм хангамж ашигладаг байна.

Цагааннуур чөлөөт бүсийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Цагааннуур чөлөөт бүсийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөлтийн үе шатанд 23 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны гуравдугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 254,964.9 мянган төгрөгөөс тооцон 5,099.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож 7,314.7 мянган төгрөгөөр тооцсон нь тус байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ, төсвийн санхүүжилтийн хэмжээ, үйл ажиллагааны орлого, зардал, эрсдэл бага байгаатай холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Цагааннуур чөлөөт бүсийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 57,453.5 мянган төгрөгөөр буюу 6.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, биет хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	14.9	4.9	-10.0
Авлага	1,749.7	429.6	-1,320.1
Урьдчилгаа	617.2	1,681.9	1,064.7
Бараа материал	4,437.1	4,888.5	451.4
Биет хөрөнгө	867,716.3	810,319.7	-57,396.6
Биет бус хөрөнгө	5,709.5	5,466.6	-242.9
Нийт хөрөнгө	880,244.7	822,791.2	-57,453.5
Өр төлбөр	1,156.0		-1,156.0

Засгийн газрын оруулсан капитал /засгийн газрын сан/	72,629.7	72,629.7	
Хуримтлагдсан үр дүн	704,406.0	648,108.5	-56,297.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	102,053.0	102,053.0	
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	880,244.7	822,791.2	-57,453.5

Авлагын дансны үлдэгдэл 1,320.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны эхний үлдэгдлээс 1,050 мянган төгрөгийн авлагыг барагдуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 451.4 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн материалын үлдэгдэл өссөнтэй холбоотой байна.

Биет хөрөнгө дансны үлдэгдэл 6.6 хувь буюу 57,396.6 мянган төгрөгөөр буурсан нь 594.0 мянган төгрөгөөр хөрөнгө нэмэгдэж, 58,233.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулснаас шалтгаантай байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга дансанд 1,156.0 мянган төгрөгийн бичилт хийгдсэн нь 2015 онд Голден пейж Аудит ХХК-д өгөхөөр өр бүртгэгдсэн байсныг тооцоо нийлсэн акт үйлдэн өр төлбөргүй болсон тул өрийг хааж бүртгэсэнтэй холбоотой байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан улсын төсвөөс 303,242.1 мянган төгрөгийн санхүүжилт, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 6,090.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлснээс 297,546.9 мянган төгрөгийг урсгал зардлын санхүүжилтэд зарцуулж 11,785.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт төсөв: Цагааннуур чөлөөт бус нь 2019 онд нэмэлт санхүүжилт аваагүй байна

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 23 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 24 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 18,820.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 12,927.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 5,892.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 12,927.1 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

1. Ээлжийн амралтын тооцоог хянахад 6 ажилтанд 503.0 мянган төгрөгийг илүү олгосон 4 ажилтанд 638.9 мянган төгрөгийн ээлжийн амралтын олговрыг дутуу олгосон байсныг залруулсан;
2. Төсөвт буцаан төвлөрүүлсэн 11,785.2 мянган төгрөгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан байсныг залруулан цэвэр дүнгээр тайлагнаж залруулсан;

Аудитаар илэрсэн 5,892.9 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал үүсээгүй.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Цагааннуур чөлөөт бүс Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 140 мэдээллийг хугацаанд нь, 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 1 мэдээллийг байршуулаагүй байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,156.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага хүргүүлснийг 2 албан шаардлагыг бүрэн биелүүлж, үйл ажиллагааг эхлүүлэх, төсвийн үргүй зардал гаргахгүй байх 1 албан шаардлагыг хэрэгжүүлээгүй нь Гаалийн ерөнхий газраас гаалийн байцаагч нарыг томилж өгөхгүй байгаа тул үйл ажиллагааг эхлүүлээгүйтэй холбоотой байна.

Нийт 1 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Цагааннуур чөлөөт бүсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 5,892.9 мянган төгрөгийн алдаа, зөрчлийн дүн бидний тогтоосон 7,314.7 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

“Зөрчилгүй” дүгнэлт

Цагааннуур чөлөөт бүсийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНБОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Хууль, эрх зүйн орчны талаар

3.1.1 Илрүүлэлт:

Засгийн газрын оруулсан капиталын дүн санхүүгийн байдлын тайланд 72,629.7 мянган төгрөг байхад улсын бүртгэлийн гэрчилгээнд 70,863.5 төгрөгөөр тусгагдаж 1,766.2 мянган төгрөгийн зөрүүтэй байна.

Энэ нь Хууль зүйн сайдын 2015 оны А/39 дүгээр тушаалын хавсралт “хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1-д “Хуулийн этгээд доор дурдсан мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлнэ”, 4.1.3.хувь нийлүүлсэн хөрөнгө; гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.1.2. Эрсдэл:

Дүрмийн сангийн хэмжээ нь санхүүгийн тайлан болон улсын бүртгэлийн гэрчилгээнд зөрүүтэй тусгах

3.1.3. Өгсөн зөвлөмж:

Улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгагдсан дүрмийн сангийн хэмжээг 72,629.7 мянган төгрөгөөр тусгуулах.

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

2003 онд Цагааннуур худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдаж “Цагааннуур” худалдааны чөлөөт бүсийг 2005 оны 7 дугаар сарын 27-ны өдөр Улсын бүртгэлийн албанд бүртгүүлж 5009235 тоот регистертэй 9070001004 дугаартай улсын бүртгэлийн гэрчилгээг авсан байна. Улсын бүртгэлийн ерөнхий газартай холбогдож, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн хүрээнд улсын бүртгэлийн гэрчилгээнд дүрмийн сангийн өөрчлөлтийг тусгуулах болно.

3.2. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

3.2.1. Илрүүлэлт:

Баян-Өлгий аймгийн төвд байрлах оффисын түрээсийн зардалд нийт 5,400.0 мянган төгрөгийг төлөхдөө түрээсийн зардлын ангиллаас 2,250.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлсний зардлын ангиллаас 2,700.0 мянган төгрөг, цэвэр бохир усны зардал тус байгууллагад огт гардаггүй байхад тус зардлын ангилалд 450.0 мянган төгрөгийг түрээсийн зардлыг бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:16.5.5-д батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Батлагдсан төсвөөс гадуур зардал гаргасан байх;

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөх, төсвийн зарлагын ангиллыг зөрүүгүйгээр зарцуулах, төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах;

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Сангийн яаманд 2016 оны төсвийн төсөөлөлд байрны түрээсийн зардал нэмүүлэх санал өгсөн боловч манай байгууллагын түрээсийн зардлыг байр ашиглалтын үйлчилгээний /80226/ зардлын Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж /210801/ ангилалд тусгаж өгсөн болно. Төрийн сан байрны түрээсийг энэ ангиллаас зарцуулахад 2016 оноос хойш зөвшөөрч гүйлгээ хийж ирсэн болно. Тиймээс 2020 оноос эхлэн зардлын ангилал хооронд шилжүүлэн ашиглах болно.

3.3. Зардлын данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Шатахууны зардлыг тооцохдоо жолоочийн тооцооны хуудсыг бүрэн хөтлөөгүй, жишиг нормын дагуу тооцоогүй 976.7 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан байна.

Энэ нь Монгол Улсын Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтад тусгагдсан “Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-той нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Батлагдсан төсөв хэтрээгүй боловч Засгийн газраас тогтоосон өдөрт явбал зохих км, цилиндрийн багтаамжтай холбоотой норм нормативыг зөрчих;

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-ын дагуу шатахууны тооцоог үнэн зөв тооцох

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Уаз фургон маркийн автомашиныг анх 2008 онд орон нутгаас ажлын хэрэгцээнд авч байсан. Уг машин 2008 онд ашиглалтад орсон, нийт гүйлт нь 300000 км. Бүх агрегат, зангилаанууд нь хуучирч элэгдсэн, хүч дамжуулах анги хуучирсан, тулгуур эд ангиуд муудсан. Элэгдэл нь тэглэсэн, ашиглалтын хугацаа дуусаж анхны өртгөө нөхсөн. Нэгэнт шинэ машин авах эдийн засгийн боломж бололцоо байхгүй тул бидний зүгээс боломжоороо засаж сэлбээд албан хэрэгцээнд ашиглаж байсан. Иймд дээрх тээврийн хэрэгслийн спидометрийн заалтыг 2020 оны урсгал засварын мөнгөөр засуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн мөрдөлтийн талаар:

3.4.1 Илрүүлэлт:

Тус байгууллагын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэхгүй, шинэчлэн боловсруулах шаардлагатай байгаад зөвлөмж өгөхөөр болсон.

Энэ нь Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2 дугаар зүйлд “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.4.2 Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, дүрэм, журмуудын өөрчлөлтийг тусгаагүй байх;

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг хууль, дүрэм журамд нийцүүлэн өөрийн байгууллагын онцлогт тохируулан боловсруулан мөрдөж ажиллах;

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Тус чөлөөт бүс нь НБББББ–г өөрсдийн нөөц боломжид нийцүүлэн боловсруулж санхүү бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана. Цаашид НБББББ-г сайжруулах тал дээр мэргэжлийн хүмүүсээс зөвлөгөө авах, шаардагдах хөрөнгийг улсын төсөвт тусгуулах тал дээр тодорхой ажлууд хийх болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	6,818,934.48	7,004,940.62
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	14,940.00	4,940.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	14,940.00	4,940.00
3121	Төгрөг	14,940.00	4,940.00
31213	Арилжааны банк дахь харилцах	14,940.00	4,940.00
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
33	АВЛАГА	1,749,648.74	429,562.04
335	Бусад авлага	1,749,648.74	429,562.04
3351	Байгууллагаас авах авлага	320,116.45	50,029.75
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,429,532.29	379,532.29
34	УРЬДЧИЛГАА	617,232.57	1,681,929.57
34600	Урьдчилж гарсан зардал	617,232.57	1,681,929.57
35	БАРАА МАТЕРИАЛ	4,437,113.17	4,888,509.01
351	Түүхий эд материал	256,200.00	256,200.00
35110	Тусгай зориулалттай материал	256,200.00	256,200.00
354	Хангамжийн материал	4,180,913.17	4,632,309.01
35410	Бичиг хэргийн материал	1,517,665.17	1,969,061.01
35470	Бусад хангамжийн материал	2,663,248.00	2,663,248.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	873,425,751.46	815,786,331.22
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	873,425,751.46	815,786,331.22
392	Биет хөрөнгө	867,716,301.45	810,319,681.17
39201	Барилга, байгууламж, орон сууц	834,893,774.80	834,893,774.80
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(47,229,796.08)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	38,000,000.00	38,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(38,000,000.00)	(38,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	59,534,616.50	59,534,616.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(30,891,555.12)	(40,521,959.40)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	5,963,772.66	5,963,772.66
39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,026,307.39)	(2,562,727.31)
39217	Ном	242,000.00	242,000.00
393	Биет бус хөрөнгө	5,709,450.01	5,466,650.05
39301	Програм хангамж	4,210,000.00	4,804,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(266,749.99)	(1,103,549.95)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,766,200.00	1,766,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	880,244,685.94	822,791,271.84

4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,156,001.53	=
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,156,001.53	-
413	Өглөг	1,156,001.53	-
4136	Бусад өглөг	1,156,001.53	-
41361	Байгууллагад төлөх өглөг	1,156,000.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1.53	-
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	879,088,684.41	822,791,271.84
51	Засгийн газрын хувь оролцоо	879,088,684.41	822,791,271.84
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	72,629,683.00	72,629,683.00
51101	Өмч: - төрийн		
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	72,629,683.00	72,629,683.00
512	Хуримтлагдсан үр дүн	704,405,966.89	648,108,554.32
51210	Өмнөх үеийн үр дүн	704,405,966.89	705,561,968.42
51220	Тайлант үеийн үр дүн	-	(57,453,414.10)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	102,053,034.52	102,053,034.52
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	880,244,685.94	822,791,271.84

4.2 Аудит хийсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	311,067,600.76	308,282,100.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,660,500.76	5,040,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,660,500.76	5,040,000.00
120005	Түрээсийн орлого	5,040,000.00	5,040,000.00
120009	Бусад орлого	1,620,500.76	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	304,407,100.00	303,242,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	304,407,100.00	303,242,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	304,407,100.00	303,242,100.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт		
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	369,535,190.80	365,735,514.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	369,166,190.80	365,735,514.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	333,214,955.83	353,050,265.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	176,395,978.22	195,882,591.11
210101	Үндсэн цалин	126,106,619.98	141,249,558.31
210102	Нэмэгдэл	33,822,258.24	37,107,932.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,467,100.00	17,525,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,338,074.73	24,984,417.59
210201	Тэтгэврийн даатгал	14,265,858.14	17,074,268.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,436,067.27	1,825,598.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,756,939.13	1,756,848.95
210204	Ажилгүйдлийн даатгал	342,091.87	393,427.42
210205	Эрүүл мэндийн даатгал	3,537,118.32	3,934,274.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,820,398.00	34,952,800.00
210301	Гэрэл, цахилгаан	1,297,908.00	1,298,000.00
210302	Түлш, халаалт	2,500,000.00	3,500,000.00
210303	Цэвэр, бохир ус	494,700.00	450,000.00
210304	Байрны түрээс	28,527,790.00	29,704,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,632,175.86	11,495,542.58
210401	Бичиг хэрэг	3,511,296.83	2,980,302.16
210402	Тээвэр, шатахуун	5,068,733.00	5,215,903.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,052,146.03	3,299,337.42
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,819,917.00	14,622,444.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	29,000.00	
210604	Урсгал засвар	15,790,917.00	14,622,444.00
2107	Томилот, зочны зардал	7,294,766.00	5,733,100.00
210702	Дотоод албан томилот	7,294,766.00	5,733,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,253,150.00	7,145,950.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	3,522,350.00	3,196,000.00
210802	үйлчилгээний төлбөр хураамж Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	1,999,950.00
210803	Даатгалын үйлчилгээ	348,600.00	348,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	199,900.00	199,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	122,300.00	1,336,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	10,000.00	10,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	61,660,496.02	58,233,420.24
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,000.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	61,625,496.02	58,233,420.24
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,951,234.97	12,685,248.58
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,734,278.00	900,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,238,701.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,495,577.00	900,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,216,956.97	11,785,248.58
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,216,956.97	11,785,248.58
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	369,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	369,000.00	-
220001	Барилга байгууламж		
221001	Их засвар		
222001	Тавилга эд хогшил	369,000.00	
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-
226001	Гадаад эх үүсвэрээр		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(58,467,590.04)	(57,453,414.10)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(58,467,590.04)	(57,453,414.10)

4.3 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	311,186,301.00	309,332,100.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,779,201.00	6,090,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,779,201.00	6,090,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,040,000.00	5,040,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,040,000.00	5,040,000.00
120009	Бусад орлого	1,739,201.00	1,050,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	304,407,100.00	303,242,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	304,407,100.00	303,242,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	304,407,100.00	303,242,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	311,196,302.00	309,342,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	311,196,302.00	309,342,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	275,245,067.03	296,656,851.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	176,522,195.00	195,612,594.00
210101	Үндсэн цалин	143,550,195.00	154,746,794.00
210102	Нэмэгдэл	20,164,200.00	28,058,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,807,800.00	12,807,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,182,936.00	24,984,328.00
210201	Тэтгэврийн даатгал	14,683,354.60	17,063,045.23
210202	Тэтгэмжийн даатгал	1,480,277.89	2,009,254.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,435,146.89	1,576,540.61
210204	Ажилгүйдлийн даатгал	322,020.74	394,135.65
210205	Эрүүл мэндийн даатгал	3,262,135.88	3,941,352.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,924,688.00	34,952,800.00
210301	Гэрэл, цахилгаан	1,297,908.00	1,298,000.00
210302	Түлш, халаалт	2,500,000.00	3,500,000.00
210303	Цэвэр, бохир ус	494,700.00	450,000.00
210304	Байрны түрээс	29,632,080.00	29,704,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,163,836.03	13,011,635.42
210401	Бичиг хэрэг	3,424,640.00	3,431,698.00
210402	Тээвэр, шатахуун	4,960,600.00	4,960,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,778,596.03	4,619,337.42
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,121,246.00	14,622,444.00
210604	Урсгал засвар	15,121,246.00	14,622,444.00
2107	Томилолт, зочны зардал	7,294,766.00	5,733,100.00
210702	Дотоод албан томилолт	7,294,766.00	5,733,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,035,400.00	7,739,950.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,466,900.00	3,790,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	1,999,950.00
210803	Даатгалын үйлчилгээ	348,600.00	348,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	199,900.00	199,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,960,000.00	1,336,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	10,000.00	10,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,951,234.97	12,685,248.58
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,734,278.00	900,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,238,701.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,495,577.00	900,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,216,956.97	11,785,248.58
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,216,956.97	11,785,248.58
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(10,001.00)	(10,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(10,001.00)	(10,000.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	24,941.00	14,940.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,940.00	4,940.00

4.4 Аудит хийсэн Цэвэр хөрөнгө/Өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөг/
				Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	70,863,483.00	886,912.59	833,161,139.69	904,911,535.28
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-	-958,957.52	-958,957.52
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	70,863,483.00	886,912.59	832,202,182.17	903,952,577.76
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	101,166,121.93	-	101,166,121.93
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	1,766,200.00	-	-	1,766,200.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн			-127,796,215.28	127,796,215.28
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	74,395,883.00	102,053,034.52	704,405,966.89	879,088,684.41
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	1,156,001.53	1,156,001.53
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	72,629,683.00	102,053,034.52	705,561,968.42	880,244,685.94
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
Тайлант үеийн үр дүн			-57,453,414.10	-57,453,414.10
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	72,629,683.00	102,053,034.52	648,108,554.32	822,791,271.84

4.5 Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	303,242,100.00	297,556,851.42	5,685,248.58	98%
УРСГАЛ ЗАРДАЛ	303,242,100.00	297,556,851.42	5,685,248.58	98%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	302,342,100.00	296,656,851.42	5,685,248.58	98%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	200,662,200.00	195,612,594.00	5,049,606.00	97%
Үндсэн цалин	159,796,400.00	154,746,794.00	5,049,606.00	96%
Нэмэгдэл	28,058,000.00	28,058,000.00	-	100%
Унаа хоолны хөнгөлөлт	12,807,800.00	12,807,800.00	-	100%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,082,800.00	24,984,328.00	98,472.00	99%
Тэтгэврийн даатгал	17,056,300.00	17,063,045.23	(6,745.23)	100%
Тэтгэмжийн даатгал	2,006,600.00	2,009,254.01	(2,654.01)	100%
ҮОМШӨ-ний даатгал	1,605,400.00	1,576,540.61	28,859.39	98%
Ажилгүйдлийн даатгал	401,300.00	394,135.65	7,164.35	98%
Эрүүл мэндийн даатгал	4,013,200.00	3,941,352.50	71,847.50	98%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,166,100.00	34,952,800.00	213,300.00	99%
Гэрэл, цахилгаан	1,298,000.00	1,298,000.00	-	100%
Түлш, халаалт	3,500,000.00	3,500,000.00	-	100%
Цэвэр, бохир ус	495,000.00	450,000.00	45,000.00	91%
Байрны түрээс	29,873,100.00	29,704,800.00	168,300.00	99%
Хангамж, бараа материалын зардал	13,170,900.00	13,011,635.42	159,264.58	99%
Бичиг хэрэг	3,431,700.00	3,431,698.00	2.00	100%
Тээвэр, шатахуун	4,960,600.00	4,960,600.00	-	100%
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,778,600.00	4,619,337.42	159,262.58	97%
Нормативт зардал	-	-	-	
Эд хогшил, урсгал засварын зардал	14,622,500.00	14,622,444.00	56.00	100%
Урсгал засвар	14,622,500.00	14,622,444.00	56.00	100%
Томилолт, зочны зардал	5,814,200.00	5,733,100.00	81,100.00	99%
Дотоод албан томилолт	5,814,200.00	5,733,100.00	81,100.00	99%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,823,400.00	7,739,950.00	83,450.00	98%
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,790,300.00	3,790,000.00	300.00	99%
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	1,999,950.00	50.00	99%
Даатгалын үйлчилгээ	348,600.00	348,600.00	-	100%
Тээврийн хэрэгслийн татвар	288,000.00	199,900.00	88,100.00	69%
Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	55,000.00	5,000.00	92%
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,336,500.00	1,336,500.00	-	100%

Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	10,000.00	(10,000.00)	0%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	900,000.00	900,000.00	-	100%
Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-	-	100%
Бусад урсгал шилжүүлэг	900,000.00	900,000.00	-	100%
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	900,000.00	900,000.00	-	100%
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-	-	
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-	-	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	303,242,100.00	297,546,851.42	5,695,248.58	98%
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	303,242,100.00	297,546,851.42	5,695,248.58	98%
Улсын төсвөөс санхүүжих	303,242,100.00	297,546,851.42	5,695,248.58	98%
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	6,090,000.00	(6,090,000.00)	0%
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	6,090,000.00	(6,090,000.00)	
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	-	-	-	
БУСАД ЭХ ҮҮСВЭР	-	-	-	
Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	-	-	-	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	14,940.00	(14,940.00)	0%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	4,940.00	(4,940.00)	0%
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	
АЖИЛЛАГСАДЫН ТОО	18	20	-2	

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2020.02.14	Аудитын нэр:	2019 оны санхүүгийн аудитын тайлан	Аудитын код:
				САГ-2020/82/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Цагааннуур чөлөөт бүсийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудит			Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллаг аас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Засгийн газрын оруулсан капиталын дүн санхүүгийн байдлын тайланд 72,629.7 мянган төгрөг байхад улсын бүртгэлийн гэрчилгээнд 70,863.5 төгрөгөөр тусгагдаж 1,766.2 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн.	1,766.2	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	А.Аманкелди М.Аманкелди
2	Баян-Өлгий аймгийн төвд байрлах оффисийн түрээсийн зардалд нийт 5,400.0 мянган төгрөгийг төлөхдөө түрээсийн зардлын ангиллаас 2,250.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлсийн зардлын ангиллаас 2,700.0 мянган төгрөг, цэвэр бохир усны зардал тус байгууллагад огт гардаггүй байхад тус зардлын ангиллаас 450.0 мянган төгрөгийг түрээсийн зардалд бүртгэсэн байна.	3,150.0	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	А.Аманкелди М.Аманкелди
3	2 тээврийн хэрэгслийг үйл ажиллагаанд ашиглаж шатахууны зардал гаргасан тооцоог тулгахад 1 тээврийн хэрэгслийн шатахууны тооцоо зөрүүгүй, 1 тээврийн хэрэгслийн жолоочийн тооцооны хуудсанд синтометрийн заалтыг бичээгүйгээс 976.7 мянган төгрөгийн шатахууны тооцоог давтан шалгах боломжгүй байна. Нягтлан бодогчоос тодруулахад 2008 оны тээврийн хэрэгсэл тул синтометрийн заалт эвдэрсэн засах боломжгүй гэж тайлбарласан	976.7	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	А.Аманкелди М.Аманкелди

4	НБББББ-т стандартын заалтууд бага тусгагдсан тухайн байгууллагын онцлогыг харуулаагүй, Ажил үүргийн хувиарыг оруулаагүй, үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох жил заасан боловч ойлгомж муутай, компьютер зэргийг аль ангилалд оруулах нь тодорхойгүй, дансны жагсаалт нь Сангийн сайдын батлагдсан дансны жагсаалт болон тухайн байгууллагын ашиглаж байгаа дансны жагсаалтаас зөрүүтэй, биет бус хөрөнгийн ашиглалтын хугацааг зааж өгөөгүй гэх мэт сайжруулах шаардлагатай байна.		Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	А.Аманкелди М.Аманкелди
	Нийт дүн	5,892.9			

